



ᠮᠣᠩᠭᠣᠯ
ᠤᠨᠳᠦᠰᠦᠨ
ᠪᠢᠴᠦᠭᠢᠨ
ᠮᠡᠳᠯᠡᠭ
ᠲᠣᠳᠣᠷᠬᠣᠢᠯᠣᠬ
ᠰᠤᠳᠠᠯᠭᠠᠭ
- 2021

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН
ҮНДЭСНИЙ БИЧГИЙН
МЭДЛЭГ ТОДОРХОЙЛОХ
СУДАЛГАА - 2021

ГАРЧИГ

УДИРТГАЛ	1
“ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ ТОДОРХОЙЛОХ”	
СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	2
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ	3
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	3
ХАМРАХ ХҮРЭЭ	3
АСУУЛГЫН ХУУДАС	4
МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ	4
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ	5
СУДАЛГААНД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ АНГИЛАЛ.....	6
СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД.....	8
АЛБАН ХЭРГЭЭ КИРИЛЛ БОЛОН ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР ХОСЛУУЛАН ХЭРЭГЛЭХЭД БЭЛЭН ЭСЭХ.....	9
ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ	12
ҮНДЭСНИЙ БИЧГИЙН СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА	18

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. СУДАЛГААНД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	5
ХҮСНЭГТ 2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТАХ-Н ТОО, ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, ХҮЙСЭЭР	8
ХҮСНЭГТ 3. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, АЛБАН ТУШААЛЫН ТӨРЛӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР	14
ХҮСНЭГТ 4. ЭХИЙГ УНШСАН БАЙДАЛ, УНШСАН ҮГИЙН ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР.....	16
ХҮСНЭГТ 5. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН БИЧИХ ЧАДВАР, АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛААР	17
ХҮСНЭГТ 6. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН СУРГАЛТАД ХАМРАГДАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА БАЙГАА ЭСЭХ, АЛБАН ТУШААЛЫН ТӨРӨЛ, НАСНЫ АНГИЛАЛААР	19

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. АЛБАН ХЭРГЭЭ КИРИЛЛ БОЛОН ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР ХОСЛУУЛАН ХЭРЭГЛЭХЭД БЭЛЭН ЭСЭХ, НАСНЫ БҮЛГЭЭР	10
ЗУРАГ 2. АЛБАН ХЭРГЭЭ КИРИЛЛ БОЛОН ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР ХОСЛУУЛАН ХЭРЭГЛЭХЭД БЭЛЭН АЛБАН ХААГЧДЫН ТОО, АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ТӨРЛӨӨР, НАС ХҮЙСЭЭР	11
ЗУРАГ 3. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, ХУВИАР	13
ЗУРАГ 4. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, ДҮҮРГЭЭР	13
ЗУРАГ 5. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР	14
ЗУРАГ 6. ӨГӨГДСӨН ЭХ УНШИХ ЧАДВАР, ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮЗСЭН ЖИЛЭЭР	15
ЗУРАГ 7. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН СУРГАЛТАД ХАМРАГДАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА БАЙГАА ЭСЭХ, ДҮҮРГЭЭР	19

УДИРТГАЛ

Монгол бичиг бол хүн төрөлхтний бүтээсэн оюуны салшгүй нэгэн хэсэг бөгөөд энэхүү бичгийг монголчууд XIII зуунаас хэл аялгуундаа тохируулан хэрэглэсээр ирсэн. Монголын ард түмний соёлын өв болсон үндэсний монгол бичгийг 1200-аад оны үед Найманы ханлигт түшмэлийн алба хааж байсан Тататунга хэмээх бичгийн хүн үйгур бичиг дээр үндэслэн зохиосон бөгөөд Чингис хаан энэхүү уламжилж ирсэн бичгийг тулгар улсын алив хэргийг явуулахын тулд албаны бичиг үсэг болгох нь зүйтэй гэж үзэн нэгдсэн төрийн албан ёсны үсгээр зарлигджээ. Монгол хэлээр бичигдсэн монгол бичгийн анхны дурсгал нь XIII зуунд урласан Санкт-петербург хотын Эрмитажид хадгалагдаж буй Чингисийн чулууны бичиг хэмээн эрдэмтэд, судлаачид үздэг байна.

XIII зуунаас эхлэн монголчууд монгол бичгийг төрийн үйл хэрэгт болон шинжлэх ухааны бүтээл туурвилыг бүтээхэд хэрэглэсээр ирсэн бөгөөд албан ёсны сонгодог төдийгүй дэлхийн бичиг соёлын нандин өв болсон. Уг бичиг нь зөвхөн босоо чиглэлд бичдэгээрээ онцлог ба үгийн эхэн дунд адагт буй үсгийн хэлбэр нь өөр өөр хэлбэртэй байдаг. Монгол бичиг нь нийгмийн хэрэглээний шаардлагыг төгс хангасан бичиг бөгөөд жишээлэхэд: Монгол бичигт ёслол хүндэтгэлд хэрэглэх хичээнгүй хэлбэр, яаруу давчуу үед хэлсэн болгоныг тэмдэглэх түргэн буюу таталган хэлбэр, үрлал чимэглэлд хэрэглэх олон зүйл эвхмэл хэлбэрүүд гэх мэт тогтолцоотой хөгжиж ирсэн аж.

Монгол Улсын Их хурлаас 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр “Монгол хэлний тухай” хуулийг баталж, 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан. Мөн хуулийн хэрэгжилтийг хангахаар даган гарсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-2020-2024”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан.

“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ын зорилго нь Монгол хэлний тухай хуульд зааснаар 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэлийг бүрэн хангахад чиглэсэн.

Үндэсний статистикийн хорооноос “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа”-г 2021 оны 4 дүгээр сарын 5-наас 30-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулсан бөгөөд энэхүү тайлангаар Нийслэлийн нэгдсэн дүнг танилцуулж байна.

Энэхүү судалгааны үр дүн нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газраас баталсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого боловсруулагчид төдийгүй судалгаа шинжилгээний ажил хийх эрдэмтэн судлаачид, бүх шатны хэрэглэгчдэд чухал мэдээллийн эх үүсвэр болно гэдэг найдаж байна.



“ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ ТОДОРХОЙЛОХ” СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ᠨᠣᠯᠠᠭ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Судалгааны зорилго нь төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлж, Монгол Улсын “Монгол хэлний тухай” хууль, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III (2020-2024)”-ын хэрэгжилтийг үнэлж, дүгнэх, цаашид үндэсний бичгийн талаар төрөөс авч, хэрэгжүүлэх бодлого, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулахад шаардлагатай тоо, мэдээллийг бий болгоход оршино.

“Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-г зохион байгуулж, төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлсноор Монгол Улсын “Монгол хэлний тухай” хуулийг дагаж мөрдөхөд бэлэн эсэх, цаашид үндэсний бичгийг төрийн албан ёсны үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд хэрэгцээтэй үе шаттай сургалтын төлөвлөгөө боловсруулахад ач холбогдолтой юм.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Их хурлаас 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр **“Монгол хэлний тухай”** хуулийг баталж, 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан. Уг хуульд үндэсний бичигтэй холбоотой дараах заалтыг тусгасан байна. Үүнд:

- 7 дугаар зүйлийн 2-т энэ хуулийн 11.1.2-т заасан “үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна”
- 11 дүгээр зүйлийн 1.2-т “монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх”
- 24 дүгээр зүйлийн 2-т 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж заасан байна.

Мөн хуулийн хэрэгжилтийг хангахаар даган гарсан **“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-2020-2024”**-ыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан.

Дээрх хууль болон Засгийн газраас баталсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай статистикийн мэдээллийг бий болгох хэрэгцээ, шаардлагын улмаас төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгааны асуулга, түүнийг нөхөх зааврыг боловсруулсан болно.

ХАМРАХ ХҮРЭЭ

Тус судалгаанд “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем”-д байгаа төрийн бүх шатны байгууллагын албан хаагч хамруулсан бөгөөд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг үндэслэн төрийн тусгай албан хаагчдыг хамруулаагүй болно.

АСУУЛГЫН ХУУДАС

Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгааны асуулга нь нийт 17 асуулттай бөгөөд төрийн албан хаагчийн ерөнхий мэдээллийн 11 асуулт, үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох 6 асуултаас бүрдсэн. Үүнд дараах мэдээллүүд багтсан.

- Нас
- Хүйс
- Боловсролын түвшин
- Төрийн албаны ангилал
- Төрийн захиргааны албан тушаалын ангилал
- Сургалтын хэрэгцээ, шаардлага
- Мэдлэгийн түвшин

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2021 оны 04 дүгээр сарын 05-наас 30-ны өдрүүдэд орон даяар зохион байгуулсан. Тус судалгаанд дүүргийн хэмжээнд нийт 1506 төрийн албан хаагчийн мэдээллийг “Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого”-ын мэдээлэлтэй тулган хүн бүрд тусгай эрх үүсгэн цахим хэлбэрээр мэдээлэл цуглууллаа.

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ

ХҮСНЭГТ 1. СУДАЛГААНД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

№	Ойлголт	Тодорхойлолт
ТӨРИЙН АЛБАН ХААГЧ		
1	Төрийн албан хаагч	Төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг хэлнэ.
2	Төрийн байгууллага, албан газар	“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д зааснаар “Төрийн байгууллага, албан газар” гэдэг нь төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг хэлнэ.
3	Төрийн алба	Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг хэлнэ.
БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ		
4	Бичиг үсэг мэддэг	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг Бичиг үсэг мэддэг гэж үзнэ.
5	Бичиг үсэг мэддэггүй	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг Бичиг үсэг мэддэггүй гэнэ.
БОЛОВСРОЛ		
6	Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгсөөгүй бол Боловсролгүй хүн гэнэ. Мөн 2020 онд ЕБС-ийн 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг Боловсролгүй гэж үзнэ.
7	Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн.
8	Техникийн болон мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль-ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн.
9	Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн.
10	Дээд боловсрол	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг Дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизм оройн дээд сургууль Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

СУДАЛГААНД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ АНГИЛАЛ

Төрийн улс төрийн албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах, мөн тэдгээрийн бүрэн эрхийн хугацаанд өөрт нь үйлчлэх орон тооны дараах албан тушаал хамаарна. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгч
- Монгол Улсын Их Хурлын дарга
- Монгол Улсын Ерөнхий сайд
- Монгол Улсын Их Хурлын дэд дарга, гишүүн
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, дэд сайд
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий сайдын зөвлөх
- Бүх шатны Засаг дарга болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч
- Улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаал
- Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаал
- Хуульд заасан бусад албан тушаал

Мөн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, хот, тосгоны захирагчийн албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаалтай адилтган үзэж болно. Улс төрийн албан хаагчийн бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтан нь тухайн албан тушаалтанд шууд захирагдах боловч төрийн албан хаагчийн хувьд тухайн байгууллагад харьяалагдана.

Төрийн захиргааны албан тушаалд Төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий дараах албан тушаал хамаарна. Үүнд:

- Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн, ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал
- Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэцийн ажлын алба, шүүхийн захиргаа, прокурорын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал
- Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал
- Яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны удирдах, гүйцэтгэх албан тушаал
- Хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлагийн удирдах, гүйцэтгэх албан тушаал
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал

- Хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх улсын төсвөөс санхүүждэг нутгийн захиргааны байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаал
- Хот, тосгоны захирагчийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал
- Хуульд заасан бусад албан тушаал

Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дараах албан тушаал хамаарна. Үүнд:

- Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга
- Монгол банкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах, гүйцэтгэх албан тушаал
- Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага
- Дипломат албан тушаал
- Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн
- Хуульд заасан бусад албан тушаал

Төрийн үйлчилгээний албан тушаалд Төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах дараах албан тушаал хамаарна. Үүнд:

- Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал;
- Боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг, спорт зэрэг төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга, захирал, эрхлэгч, бусад удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал;
- Яам, агентлагийн харьяа болон түүний дэргэд ажилладаг, төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал.

Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалыг доор дурдсанаар ангилна. Үүнд:

Тэргүүн түшмэл: Яамны Төрийн нарийн бичгийн дарга, түүнтэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

Эрхэлсэн түшмэл: Яамны газрын дарга, хэлтсийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

Ахлах түшмэл: Яамны тасгийн дарга, ахлах шинжээч, шинжээч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

Дэс түшмэл: Яамны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, ахлах зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна. Туслах түшмэл: Яамны зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД

“Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-нд “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (цаашид “ХНУМТ” гэх) цахим систем”-д бүртгэлтэй байгаа нийслэлийн нийт 33 байгууллагын 1506 ажилтан, албан хаагчийг хамруулж, тэдгээрийн үндэсний бичгийн мэдлэгийг төрийн албаны ангилал, албан тушаалын төрөл, насны бүлэг, хүйсээр задлан, холбогдох үзүүлэлтийн хүрээнд шаардлагатай бусад мэдээллийг цуглуулав.

Судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 381 (25.3%) нь эрэгтэй, 1125 (74.7%) нь эмэгтэй албан хаагчид байна. Насны бүлгээр авч үзэхэд 25 хүртэлх насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд) 3.4 хувь, 25-аас 54 насныхан (ерөнхий ажиллах хүчний насныхан) 85.8 хувь, 55-аас дээш насныхан 10.7 хувийг эзэлж байв.

Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг “маш сайн”, “сайн”, “дунд зэрэг”, “бага зэрэг”, “үгүй, мэдлэггүй” гэсэн түвшингээр үнэлэв.

ХҮСНЭГТ 2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ТАХ-Н ТОО, ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, ХҮЙСЭЭР

	Судалгаанд хамрагдсан ТАХ-н тоо, бүгд	Үүнээс	
		Эрэгтэй	Эмэгтэй
Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагч,			
Маш сайн мэддэг	97	11	86
Сайн мэддэг	196	34	162
Дунд зэрэг	437	89	348
Бага зэрэг	384	101	283
Мэдлэггүй	392	146	246
Албан тушаалын төрлөөр			
Удирдах	106	37	69
Гүйцэтгэх	971	214	757
Туслах	429	130	299




АЛБАН ХЭРГЭЭ КИРИЛЛ БОЛОН ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР ХОСЛУУЛАН ХЭРЭГЛЭХЭД БЭЛЭН ЭСЭХ

/ХУВИЙН ЖИНГЭЭР/

Судалгаанд хамрагдсан нийт алба хаагчдын 824 (54.7%) нь төрийн албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн гэж хариулсан байна. Тухайлбал 15-24 насны албан хаагчдын 34 (65.4%) нь, 25-29 насны албан хаагчдын 104 (56.2%) нь, 30-34 насны насны албан хаагчдын 132 (53.6%) нь, 35-39 насны насны албан хаагчдын 155 (63.8%) нь, 40-44 насны насны албан хаагчдын 135 (64.3%) нь, 45-49 насны насны албан хаагчдын 109 (52.1%) нь, 50-54 насны насны албан хаагчдын 87 (43.7%) нь, 55-59 насны насны албан хаагчдын 50 (47.2%) нь, 60-64 насны насны албан хаагчдын 18 (40.9%) нь, 65-69 насны насны албан хаагчдын 4 (50.0%) нь, 70-аас дээш насны насны албан хаагчдын 1 (25.0%) нь Төрийн албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн гэжээ. Эндээс харахад Үндэсний бичиг 1-р ангиасаа эхлэн үзсэн буюу 35-39 насны бүлэгт хамрагдах албан хаагчдын 63.8 хувь нь хос бичиг хэрэглэхэд бэлэн гэж хариулсан нь хамгийн өндөр хувь байна.

ЗУРАГ 1. АЛБАН ХЭРГЭЭ КИРИЛЛ БОЛОН ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР ХОСЛУУЛАН ХЭРЭГЛЭХЭД БЭЛЭН ЭСЭХ, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



Албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн гэж хариулсан 824 алба хаагчийг төрийн албан тушаалын төрлөөр авч үзвэл 8.1 хувь нь удирдах, 65.9 хувь нь гүйцэтгэх, 26.0 хувь нь туслах ажилтан байна. Харин удирдах албан тушаалтны 63.2 хувь нь, гүйцэтгэх түвшний албан хаагчдаас 58.9 хувь нь, туслах ажилтны 50.1 хувь нь хос бичгээр албан хэргээ явуулахад бэлэн гэжээ.

ЗУРАГ 2. АЛБАН ХЭРГЭЭ КИРИЛЛ БОЛОН ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР ХОСЛУУЛАН ХЭРЭГЛЭХЭД БЭЛЭН АЛБАН ХААГЧДЫН ТОО, АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ТӨРЛӨӨР, НАС ХҮЙСЭЭР

ХҮЙС




381
25.3%



1 125
74.7%

НАСНЫ АНГИЛАЛ, ХУВИАР



ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН ТӨРӨЛ

Удирдах



8.1%

Гүйцэтгэх



65.7%

Туслах




26.2%




ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ

ᠤᠨᠳᠡᠰᠦᠨᠢ
ᠪᠢᠴᠢᠭᠢᠨ
ᠮᠡᠳᠯᠡᠭ



ЗУРАГ 3. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР




Үндэсний бичгийг судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 6.4 хувь нь маш сайн, 13.0 хувь нь сайн, 29.0 хувь нь дунд зэрэг, 25.6 хувь нь бага зэрэг, 26.0 хувь нь огт мэддэггүй гэсэн байна.

Маш сайн мэддэг гэж хариулсан албан хаагчдыг насны бүлгээр авч үзвэл 15-19 нас 0.0 хувь, 20-24 нас 5.1 хувь, 25-29 нас 11.3 хувь, 30-34 нас 12.4 хувь, 35-39 нас 16.5 хувь, 40-44 нас 19.7 хувь, 45-49 нас 18.6 хувь, 50-54 нас 7.2 хувь, 55-59 нас 5.2 хувь, 60-64 нас 3.0 хувь, 65-69 настай 1.0 хувь нь байна.

Үндэсний бичгийг маш сайн мэднэ гэж хариулсан албан хаагчдаас 40-44 насны албан хаагчид хамгийн өндөр хувийг эзэлж байв. 1990-ээд оноос үндэсний бичгээ сэргээн сурахад төр засаг анхаарч “Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр”-ийг баталж, үндэсний бичгийг сурах хөдөлгөөн орон даяар өрнүүлэн дунд сургуулийн нэгдүгээр ангиас эхлэн түрээ туршсан нь юм.


Албан хаагчдын бичиг үсгийн мэдлэгийг дүүргээр задалж харуулахад Налайх (6.4%), Баянзүрх (6.4%) дүүргийн маш сайн мэддэг гэж хариулсан албан хаагчийн эзлэх хувь хамгийн өндөр байсан бол Баянгол (28.6%), Багануур (28.3%) дүүргийн хувьд мэдлэггүй гэж хариулсан албан хаагчийн эзлэх хувь өндөр байна.

ЗУРАГ 4. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, ДҮҮРЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



Судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдыг хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүдийн үндэсний бичгийн мэдлэг эрэгтэйчүүдээс илүү байна. Тухайлбал үндэсний бичгийг маш сайн мэддэг эмэгтэй албан хаагчдын дүнд эзлэх хувь эрэгтэйчүүдээс 4.7 пунктээр илүү байхад үгүй, мэдлэггүй гэж хариулсан албан хаагчдын дүнд эзлэх хувь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 16.5 пунктээр илүү байлаа.

ЗУРАГ 5. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



ХҮСНЭГТ 3. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ, АЛБАН ТУШААЛЫН ТӨРЛӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР

	Бүгд	Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Бага зэрэг	Мэдэхгүй
Албан тушаалын төрлөөр						
Удирдах	100.0	9.4	25.6	34.9	16.9	13.2
Гүйцэтгэх	100.0	7.7	15.8	32.6	25.5	18.4
Туслах	100.0	2.8	3.5	19.3	27.8	46.6
Төрийн захиргааны албан тушаалын ангиллаар						
Бүгд	100.0	4.0	16.5	36.9	29.0	13.6
Тэргүүн түшмэл	100.0	50.0	-	50.0	-	-
Эрхэлсэн түшмэл	100.0	-	37.5	37.5	25.5	-
Ахлах түшмэл	100.0	-	-	55.5	44.5	-
Дэс түшмэл	100.0	2.7	17.7	39.8	30.0	9.8
Туслах түшмэл	100.0	6.8	13.6	25.0	25.0	29.5
Боловсролын түвшнээр						
Боловсролгүй	100.0	-	-	-	33.3	66.7
Бага	100.0	12.5	-	37.5	12.5	37.5
Суурь	100.0	-	1.7	13.8	20.7	63.8
Бүрэн дунд	100.0	2.2	2.2	15.1	30.7	49.8


Техник болон мэргэжлийн	100.0	-	4.5	9.0	27.9	58.6
Тусгай мэргэжлийн дунд	100.0	-	9.8	13.6	28.4	48.2
Дипломын дээд	100.0	13.1	12.1	23.3	27.1	24.4
Бакалавр	100.0	7.8	15.9	37.5	25.4	13.4
Магистр	100.0	10.2	24.6	40.4	19.1	5.7
Доктор	100.0	20.0	20.0	20.0	20.0	20.0

Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын албан тушаал болон боловсролын түвшин нэмэгдэх тусам үндэсний бичгийн мэдлэг нэмэгдэж байгаа нь хүснэгтээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл удирдах албан тушаалтны 9.4 хувь, гүйцэтгэх албан тушаалтны 7.7 хувь, туслах ажилтны 2.8 хувь нь үндэсний бичгийг маш сайн мэднэ гэж хариулав. Мөн боловсролын түвшнээр авч үзэхэд доктор зэрэгтэй албан хаагчид хамгийн өндөр буюу 20.0 хувь нь маш сайн мэднэ гэсэн бол бүрэн дунд боловсролтой албан хаагчид хамгийн бага буюу 2.2 хувь нь маш сайн мэднэ гэжээ.

УНШИХ ЧАДВАР: Судалгаагаар үндэсний бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй (74.0%) гэж хариулсан албан хаагчдад энгийн, богино өгүүлбэрийг уншуулж, бүтэн уншиж чадсан эсэх, үгүй бол хэдэн үг уншсан, уншаад ойлгосон эсэхийг нь тодруулах байдлаар унших чадварыг тодорхойлсон. Мөн өгөгдсөн эх унших чадварыг үндэсний бичиг үзсэн жил, нас хүйсээр нарийвчлан гаргав.

Үндэсний бичгийн тодорхой хэмжээний мэдлэгтэй гэж хариулсан албан хаагчдын 10 хүн тутмын 1 нь буюу 13.9 хувь нь өгөгдсөн эхийг огт уншиж чадаагүй бол 49.9 хувь нь зарим хэсгийг, 36.2 хувь нь бүтнээр нь уншиж чадсан байна.

ЗУРАГ 6. ӨГӨГДСӨН ЭХ УНШИХ ЧАДВАР, ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮЗСЭН ЖИЛЭЭР



Зураг 6-оос харахад 3-аас дээш жил үндэсний бичиг үзсэн албан хаагчдын тал хэсэг хувь нь өгөгдсөн эхийг бүтнээр нь уншиж чадсан байна. Мөн эхийг бүтнээр нь уншиж чадсан нийт төрийн албан хаагчдын 11.7 хувь нь 1 жил хүртэл, 22.6 хувь нь 1-2 жил, 19.3 хувь нь 2-3 жил, 14.6 хувь нь 3-4 жил, 12.6 хувь нь 4-5 жил, 19.2 хувь нь 6 ба түүнээс дээш жилээр суралцсан байна.

Унших чадварыг хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүдийн 28.1 хувь нь эхийг бүтнээр нь, 53.6 хувь нь зарим хэсгийг, 18.3 хувь нь огт уншиж чадаагүй бол эмэгтэйчүүдийн 38.3 хувь нь эхийг бүтнээр нь, 48.9 хувь нь зарим хэсгийг, 12.7 хувь нь огт уншиж чадаагүй. Эндээс харахад эхийг бүтэн уншсан албан хаагчдын эзлэх хувь эмэгтэйчүүдийнх эрчүүдээс 10.2 пунктээр илүү байна.

Үндэсний бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй буюу өгөгдсөн эхээс зарим хэсгийг нь уншсан гэж хариулсан албан хаагчдыг уншсан үгийн тоогоор нь авч үзэхэд 22.1 хувь нь 10 хүртэл үг, 31.1 хувь нь 10-20 үг, 28.5 хувь нь 20-30 үг, 18.3 хувь нь 30-аас дээш үг уншсан байна.

ХҮСНЭГТ 4. ЭХИЙГ УНШСАН БАЙДАЛ, УНШСАН ҮГИЙН ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР


	Эхийг унших чадвар				Уншсан үгийн тоо, бүлэглэсэн				
	Бүгд	Огт уншиж чадаагүй	Зарим хэсгийг уншсан	Бүтнээр нь уншсан	Бүгд	10 хүртэл	10-20	20-30	30-аас дээш
Төрийн албан хаагчдын хүйсээр									
Бүгд	100.0	13.9	49.9	36.2	100.0	22.1	31.1	28.5	18.3
Эрэгтэй	100.0	18.3	53.6	28.1	100.0	24.6	34.1	28.6	12.7
Эмэгтэй	100.0	12.7	48.9	38.3	100.0	21.4	30.2	28.6	19.8
Албан тушаалын төрлөөр									
Удирдах	100.0	8.8	46.7	44.5	100.0	11.6	39.5	39.5	9.4
Гүйцэтгэх	100.0	12.7	48.4	38.9	100.0	19.3	30.3	30.3	20.1
Туслах	100.0	20.0	56.8	23.2	100.0	33.8	30.7	20.0	15.5

БИЧИХ ЧАДВАР: Судалгаагаар үндэсний бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй (75.6 хувь нь) гэж хариулсан албан хаагчдын унших чадварыг тодорхойлноос гадна бичих чадварыг мөн тодорхойлсон. Үндэсний бичгийн тодорхой хэмжээний мэдлэгтэй нийт албан хаагчдаас 14.6 хувь нь үндэсний бичгээр сайн бичиж чадна, 35.0 хувь нь дунд зэрэг бичиж чадна, 39.6 хувь нь бага зэрэг бичиж чадна, 10.8 хувь нь үгүй, бичиж чадахгүй гэж хариулжээ.

ХҮСНЭГТ 5. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН БИЧИХ ЧАДВАР, ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АНГИЛЛААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР

	Бүгд	Тийм, сайн бичиж чадна	Тийм, дунд зэрэг бичиж чадна	Тийм, бага зэрэг бичиж чадна	Үгүй, бичиж чадахгүй
Бүгд	100.0	14.6	35	39.6	10.8
Төрийн улс төрийн алба	100.0	15.6	29.4	41.2	13.8
Төрийн захиргааны алба	100.0	10.5	40.8	36.8	11.8
Төрийн тусгай алба	100.0	7.1	32.1	53.7	7.1
Төрийн үйлчилгээний алба	100.0	15.5	34.4	39.5	10.6


ҮНДЭСНИЙ БИЧГИЙН СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА



Цаашид үндэсний бичгийг төрийн албан ёсны үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд хэрэгцээтэй үе шаттай сургалтын төлөвлөгөө боловсруулахад чухал ач холбогдол бүхий төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтын хэрэгцээг тодорхойлов.

Судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 88.6 хувь нь үндэсний бичгийн сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага байна гэж үзжээ. Үндэсний бичгийн сургалтын хэрэгцээг дүүргээр харахад Налайх дүүрэг хамгийн өндөр 88.6 хувь, Баянгол дүүрэг хамгийн бага 77.5 хувь байна.

ЗУРАГ 7. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН СУРГАЛТАД ХАМРАГДАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА БАЙГАА ЭСЭХ, ДҮҮРЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



Сургалтын хэрэгцээ шаардлагыг албан тушаалын төрлөөр нь задалбал удирдах албан тушаалтны 88.7 хувь, гүйцэтгэх албан тушаалтны 88.3 хувь, туслах ажилтны 89.0 хувь нь сургалтад хамрагдах шаардлагатай гэжээ.

ХҮСНЭГТ 6. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН СУРГАЛТАД ХАМРАГДАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА БАЙГАА ЭСЭХ, АЛБАН ТУШААЛЫН ТӨРӨЛ, НАСНЫ АНГИЛАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР

	Тийм	Сургалтын хэлбэр		
		Онлайн сургалт	Танхимын сургалт	Бусад
Албан тушаалын төрлөөр				
Бүгд	88.6	32.1	57.9	10.0
Удирдах	88.7	43.6	44.7	11.7
Гүйцэтгэх	88.3	32.3	57.0	10.7
Туслах	89.0	29.0	62.8	8.2
Насны бүлэг				
15-24	90.4	38.3	44.7	17.0
25-29	92.9	33.7	55.3	11.0
30-34	94.3	32.8	55.2	12.0
35-39	86.8	33.6	54.5	11.8
40-44	88.1	33.5	57.8	8.7
45-49	87.5	31.7	63.4	4.9
50-54	85.9	27.5	61.4	11.1
55-59	85.8	31.8	62.6	5.6
60+	75.0	23.8	64.3	11.9

Тэмдэглэл

